



УЛС ТӨР
 Д.ХАЯНХЯРВАА: SSPON УЛСЫН
 850 САЯ АМ.ДОЛЛАРЫН ЗЭЭЛЭЭР
 ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ НӨХНӨ
II нүүрт

ДЭЛХИЙ
 БНСУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
 СОНГУУЛД НЭР ДЭВШИГЧИД ХАЛЗ
 МЭТГЭЛЦЛЭЭ
IV нүүрт

Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

Даатгалын
 компаниудын далд
 луйврыг зогсооё
 Г.ДОРЖ

Монголын зах зээлд даатгалын компаниуд хамгийн бага зардлаар хамгийн өндөр ашгийг олж буй. Тэдний үйл ажиллагаа өдрөөс өдөрт өөдлөн дэвжиж байгааг төвхнөж, тохижсон байшин барилгаас нь харж болно. Хүний амьдралд юу эс тохиолддог билээ. Гал ус, гэнэтийн аюул нүүрлэсэн үед даатгалтай иргэн, аж ахуйн нэгж л хождог. Ингээд бодохоор даатгал та бидний амьдралд ус агаар мэт хэрэгтэй. Гэхдээ өнөөдөр бидэнд үйлчилж буй даатгалын системд нэн даруй засч залуулбал зохих алдаа байна. Жишээ нь, иргэд унаж буй тээврийн хэрэгслээ банк бус санхүүгийн байгууллагад барьцаалан тав хүртэлх сая төгрөгийн зээл авдаг үйлчилгээ нэвтэрсээр даруй долоон жилийн нүүр үзэж байгаа.

Н.ПУНЦАГБОЛЦ

Нэг хэсэгтээ л унтаад байсан улс төр сэргэж эхэллээ. Ерөөс

хаврын чуулган нээлтээ хийхтэй зэрэгцээд маш олон асуудал зэрэгцэж ургасан.

Наад зах нь ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах эсэхийг шийдэх. Хөтөлбөрийн хүрээнд долоон төрлийн татвар

нэмэх эсэхийг шийдэхээс авахуулаад асуудал их байсан. Тэр бүхнийг Засгийн газар, УИХ бүрэн эрхийнхээ хүрээнд

шийдэж, олонхийн хүчээр шийдвэрлээд явж байна. Мэдээж энэ бүхний хажуугаар сөрөг хүчин, жагсагчид, парламентад суудалтай болоод суудалгүй намуудын төлөөлөл дуугүй байхгүй нь мэдээж. Янз бүрээр улс төр хийж эхэллээ. Оффшор данстай холбоотой улстөржилтийн барьцтай ч болчихоод байна. Энэ бүхний хажуугаар ирэх зургадугаар сард болох Ерөнхийлөгчийн сонгуулийг угтсан их улстөржилт эхэлчихлээ. Аль намаас хэн нэр дэвших, хэн нь боломж хайж хаашаа явах вэ гээд улс төрийн халууны улирал ч эхэлж байна даа.

Үргэлжлэл нь III нүүрт

ХАВРЫН УЛС ТӨР ХАЛУУЦУУЛЖ ЭХЭЛЛЭЭ



МОНГОЛЫН МЭДЭЭ
 Манай сонины II улирлын нэмэлт захиалга явагдаж байна
 Захиалгын үнэ **19800**
 Монгол шуудан: 70078977
 УБ шуудан: 70127027
 Скай пост: 70121294
 Түгээмэл шуудан: 70115025

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ
С.БАЯСГАЛАН: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БҮРИЙН ЦААНА ХАРИУЦЛАГА БАЙХ ЁСТОЙ
 Х.СОЁЛ-ЭРДЭНЭ
 Хөрөнгө оруулалтын ажлын нээлтийн үеэр Дархан-Уул аймагт хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын талаар аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Баясгалантай ярилцлаа.
 -Энэ жилийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудын талаар илүү тодорхой мэдээлэл хэрэгтэй байна. Өнгөрсөн жилүүдэд эхлүүлсэн зарим ажлууд үргэлжлэх үү?
 -Тэгэлгүй яах вэ. Тухайлбал, "Жишиг хороолол-5" төслийг Дархан сумын тавдугаар багт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус багийн 20-4, 20-7 дугаар байрны гадна сүүдрэвч, сагсан бөмбөгийн талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, хүүхдийн тоглоомын талбай бүхий тохижилтын ажил болон авто машины зогсоол шинээр гаргах ажлыг 110 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, Эрүүл мэндийн газраас нийтийн орон сууцны 2-60 байр хүртэлх явган зам ногоон байгууламжийн ажилд нийт 51 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэнэ.
 Үргэлжлэл нь VI нүүрт

Barilla Италийн №1
 Tortiglioni, Canneloni, Basilico
 GreenCity Албан ёсны дистрибутор
 Утас: 457893

| ХААН банк | | | | | Худалгаа хөгжлийн банк | | | | | | |
|-----------|---------|---------|-------|---------|------------------------|-----------|---------|---------|-------|---------|---------|
| | Авах | Зарах | | Авах | Зарах | | Авах | Зарах | | Авах | Зарах |
| АМ.ДОЛЛАР | 2415.00 | 2429.00 | ФУНТ | 3054.00 | 3148.00 | АМ.ДОЛЛАР | 2416.00 | 2428.00 | ФУНТ | 3064.00 | 3146.00 |
| ЕВРО | 2592.00 | 2659.00 | РУБЛЬ | 42.30 | 44.40 | ЕВРО | 2589.00 | 2662.00 | РУБЛЬ | 41.66 | 44.89 |
| ИЕН | 21.87 | 22.19 | ЮАНЬ | 350.00 | 353.40 | ИЕН | 21.72 | 22.36 | ЮАНЬ | 350.00 | 353.40 |

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

“Эрдмийн баяр” тэмдэглэх тухай тушаал гарлаа

Ж.ОТГОН

БСПУС-ын сайдын “Эрдмийн баяр” тэмдэглэх тухай тушаал гарлаа. Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.15 дугаар заалт, 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.2.7 дугаар заалтыг тус тус үндэслэн бүх шатны боловсролын байгууллагыг төгсөгчдийн төгсөлтийн баярыг урлаг, спорт, багш шавийн “Эрдмийн баяр” болгон зохион байгуулж байх зорилгоор уг тушаалыг гаргажээ. Тушаалд “Эрдмийн баяр”-ыг тэмдэглэх нэрээр төгсөгчдөөс хуульд заагаагүй төлбөр, хураамж авах, төгсөгчид, эцэг, эх, асран хамгаалагчдад нь дарамт, хүндрэл учруулах, хөдөө хээр, амралт зуслан, голын сав, жуулчны бааз, зочид буудал, цэнгээний газруудад зохион байгуулах, архи, согтууруулах ундаа хэрэглүүдэхийг хориглосон байна. Энэхүү тушаал, шийдвэрийг бүх шатны сургалтын боловсролын байгууллагын захирал, эрхлэгчдэд хүргүүлээд байна.

ХААЛТАЙ ХУРАЛДААН

Д.ХАЯНХЯРВАА:

Япон улсын 850 сая ам.долларын зээлээр төсвийн алдагдлыг нөхнө



Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

Ж.МЯГМАР

УИХ дахь намын бүлгүүд уламжлалт ёсоор Төрийн ордонд хуралдлаа. УИХ дахь Ардчилсан намын бүлэг хуралдаж, Зөрчлийн тухай хуулийн төсөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцсэн байна. Гэхдээ хуралдааны дараа хэвлэлийн хурал хийсэнгүй. Харин УИХ дахь МАН-ын бүлэг өчигдөр үдээс өмнө хуралдаж байгаад завсарласан. Дугаар шилжих мөчид буюу 17.00 цагт үргэлжлүүлж хуралдах тов гарсан байв. Үдээс өмнөх хуралдаанаар Зөрчлийн тухай хуулийн төсөл, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцсэн байна. Энэ үеэр тэрбээр сэтгүүлчдийн сонирхсон цаг үеийн зарим асуултад хариулт өглөө.

төслийг хэлэлцсэн байна. УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваагийн хэлж буйгаар үдээс хойшхи хуралдаанаар эдгээр төслүүдээр бүлгийн гишүүдийнхээ байр суурийг нэгтгэгчээр болсон аж.

Энэ үеэр тэрбээр сэтгүүлчдийн сонирхсон цаг үеийн зарим асуултад хариулт өглөө.

“Ерөнхийлөгчийн сонгуулийн хандивыг МАН цуглуулаад эхэлсэн гэсэн мэдээлэл байна?”

“Манай нам удирдах зөвлөл өнөөдөр /өчигдөр/ хуралдаж, сонгуулийн хандив цуглуулах ажлын хэсгийн ахлагчаар би сонгогдсон. Өнөөдрийг хүртэл энэ чиглэлээр хуулийн

хугацаа болоогүй учир нэг ч удаа хуралдаагүй байгаа. Ерөнхийлөгчийн сонгуулийн хандив гэж нэг ч төгрөг цуглуулаагүй. Бид хуулийн хүрээнд ажиллана.

“Валютын сангийн санхүүжилт хэзээ орж ирэх юм бэ. Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө зарим зарцуулалт нь орж ирнэ гэсэн сураг байсан. Үнэн үү?”

“Валютын сангийн захирлуудын зөвлөлийн хурал энэ сарын 28-нд болно. Уг хурлаар санхүүжилт хэзээ орж ирэх эсэх шийдвэр гарна. Япон улсын зүгээс манайд 850 сая ам.долларын зээл олгохоор болсон. Үүнийг төсвийн алдагдлыг нөхөхөд ашиглахаар төлөвлөдөг байгаа. Харин Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон бусад

донор орнуудаас орж ирэх хөрөнгө санхүүг чухам ямар зориулалттай яаж зарцуулах вэ гэдгийг яриа хэлэлцээрийн үр дүнд шийднэ. Түүнээс биш Валютын сангийн мөнгө орж ирэхэд намын бүлэг хурлаараа яриад л тал, тал тийш нь хуваагаад авчих гээд байгаа юм байхгүй.

“Гурван төрлийн татварыг ирэх сарын 01-ээс хэрэгжж эхэлнэ. Үүнийг хойшлуулах эсэх асуудлыг намын бүлгийн хурал дээр ярьж байгаа юу?”

“Татвар нэмж, ард түмний нуруун дээр ачаа үүрүүлчихлээ гэдэг шүүмжэл МАН-д ирж байгаа бид ойлгож байгаа. Гэхдээ яг үнэндээ татвар нэмэгдэх энэ асуудал олонхид хүрч, хүндээр тусч байгаа асуудал биш. Татварын хуулийг

...Татвар нэмж, ард түмний нуруун дээр ачаа үүрүүлчихлээ гэдэг шүүмжэл МАН-д ирж байгаа бид ойлгож байгаа. Гэхдээ яг үнэндээ татвар нэмэгдэх энэ асуудал олонхид хүрч, хүндээр тусч байгаа асуудал биш...

маш сайн судлах ёстой. Мэдээж бид ерөнхийлөгчийн сонгуулийг бодож, улс төрийн ашиг хонжоо хайх зорилгоор татварын хуулийг нэг, хоёр сараар хойшлуулна гэвэл бид Валютын сангийн хөтөлбөргүй үлдэх ийм л нөхцөлд байна. Бид улс орныхоо эрх ашгийг бодсон зөв сонголт хийсэн. Харин ард иргэд ойлгоосой гэж хүсч байна. Валютын сангаас тусламж авахын тулд татвар нэмэхээс өөр ямар ч сонголт, боломж алга. Хамгийн сүүлд л гэхэд 11 хувийн хүүтэй 750 сая ам.долларыг зээлж байсан. Тэгвэл сая зээлийн хүүг 8.75 гэж 10 оронтой тоо руу орууллаа. Энэ мэтчилэн арилжааны урт хугацаатай зээлийн хугацааг нь ихэсгэж, хүүг нь бага болгох арга замуудыг хайж байна.

О.Баасанхүү:

Парламент дахь гуравдагч хүчнийг үзүй хийх нь

О.Баасанхүү гишүүн УИХ-ын чуулганы танхимын үүдэнд сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Тэрбээр УИХ-ын даргын үүдэнд ширээ сандлаа зөөж аваачсан бөгөөд өчигдөр өглөө ажилдаа ирэхэд нь УИХ-ын Тамгын газраас албан өрөөгөө суллаж өгөхийг хүссэн бичиг хүргүүлсэн аж. Хэвлэлийн хурлыг УИХ-ын даргын үүдэнд зассан ширээнийхээ хажууд хийхийг хүссэн ч Төрийн ордны хамгаалалтын албанаас зөвшөөрөгүй байна. Энэ үеэр тэрбээр “Би сүүлийн үед УИХ-аар хэлэлцэж буй хэд хэдэн



Хувийг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтэст. Улсын Их Хурлын гишүүн миний бие Төрийн ордон дахь өөрийн албан өрөөгөө жанжин Д.Сүхбаатарын төв талбайд шилжүүлэх болсонтой холбогдуулан монгол гэр барих зөвшөөрөл олгохыг хүсье.

Хувийг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтэст. Улсын Их Хурлын гишүүн миний бие Төрийн ордон дахь өөрийн албан өрөөгөө жанжин Д.Сүхбаатарын төв талбайд шилжүүлэх болсонтой холбогдуулан монгол гэр барих зөвшөөрөл олгохыг хүсье.

Хувийг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтэст. Улсын Их Хурлын гишүүн миний бие Төрийн ордон дахь өөрийн албан өрөөгөө жанжин Д.Сүхбаатарын төв талбайд шилжүүлэх болсонтой холбогдуулан монгол гэр барих зөвшөөрөл олгохыг хүсье.

асуудалд шүүмжлэлтэй хандаж байгаа. Тухайлбал, Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийг батлах замаар Хятадын банк оруулж ирэх гэж буй явдлыг шүүмжилсний төлөө Ч.Хүрэлбаатар гишүүн намайг доромжилсон. Улмаар Л.Энх-Амгалан, Ц.Нямдорж нар над руу нэлээд дайрсан. Гэтэл өнөө өглөө ажилдаа иртэл албан өрөөгөө суллаж өгөхийг шаардсан бичиг ирүүлсэн байна. Энэ бол парламент дахь гуравдагч хүчнийг үгүй хийх гэсэн ерөнхийлөгчийн сонгууль угтсан шоу юм” хэмээлээ. Мөн тэрбээр “Парламентад УИХ дахь МАН-ын бүлгийн 65 гишүүн байгаа, тэднээс нэг нь өрөөгөө суллаад өгч болно. Уггүй бол тэднийхээ нэг өрөөнд нь намайг оруулж болно. Ийм байдалд хүргэсний цаад санаа нь О.Баасанхүү улс төрийн акци биш өрөөний хэрүүл хийдэг гэдэг ойлголт төрүүлэх гэж байна” гэлээ. Харин УИХ-ын Тамгын газраас өгч буй

Ерөнхийлөгч Дорнод аймагт ажиллаж байна

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж энэ сарын 24-25-ны өдрүүдэд Дорнод аймагт ажиллаж байна. Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009-2017 оны бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг Дорнод аймгийн иргэдэд танилцуулах уулзалт болно.

Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Л.Пүрэвсүрэн, Хүний хөгжил, нийгмийн бодлогын зөвлөх Р.Болд, Хүний эрх, хуулийн бодлогын зөвлөх Ч.Өнөрбаяр нар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн өнгөрсөн найман жилийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлыг салбар тус бүрээр нь танилцуулах уулзалт болно. Уулзалтын дараа Дорнод аймгийн Төрийн дээд Сүхбаатарын одонгоор шагнах ёслол болох аж. Ц.Элбэгдорж Дорнод аймагт ажиллах үеэрээ зүүн болон говийн бүсийн аймгуудын телевиз, сонины сэтгүүлчидтэй мөн уулзалт, ярилцлага хийх ажээ.

“Монголын зэс” корпораци шаардах бичиг хүргүүлээ

“Монголын зэс” корпораци ТӨБЗГ-ын дарга Ц.Ням-Осорт өчигдөр “Эрдэнэт” үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой, үр ашигтай явуулах асуудлаар шаардах бичиг хүргүүлэхээр очсон ч Ц.Ням-Осор дарга хүлээн авсангүй. Тиймээс тус корпорацийн Гүйцэтгэх захирал Ц.Пүрэвтүвшин шаардах бичгээ тус байгууллагын бичиг хэрэгт хүлээлгэн өгсөн юм.

Үйлдвэрийн удирдлагын зардал, цалин урамшуулал, төрийн тансаглалтай холбоотой баримтаар нотлогдсон олон удаагийн үйлдэлд хувийн хэвшлийн төлөөлөл санаа зовж байгаа учраас шаардах бичигт нийт гурван шаардлагыг тусгасан гэдгээ Ц.Пүрэвтүвшин захирал онцолж байлаа.

Тухайлбал, тус үйлдвэрийн удирдлагуудаас “Эрдэнэт” үйлдвэрийн ажилчдын цалинг нэмэхийг шаарджээ. “Монголын зэс” корпораци 2016

оны аравдугаар сараас эхлэн инженер техникийн болон бусад ажилтнуудын цалинг 10 хүртэл хувиар нэмэгдүүлэх санал гаргасан ч зөвшилцөлд хүрээгүй аж.

Мөн, үйлдвэрийн ерөнхий захирлын цалинг 25 сая төгрөгөөр тогтоосон нь төрийн зүгээс түүний хэмжээг хязгааргүй тансаглалыг өөгшүүлж байгааг үндэслэжээ. Нэгдүгээр зөгсоохыг шаарджээ. Нөгөөтэйгүүр хууль бус ТУЗ үйлдвэрийн 200 мэргэжлийн ажилтныг хомроглон халж, оронд нь намын харьяалалтай, зорилго нь тодорхойгүй 200 хүнийг томилхоор эзэж байгааг эрс эсэргүүцэн, энэ байдлыг зөгсоохыг шаардлаа. Эрдэнэт үйлдвэрт сүүлийн 26 жилийн хугацаанд 6.1 тэрбум ам.долларын биет бараа бүтээгдэхүүнийг шахсан нь ОХУ-н тусгай аудитын шалгалтаар тогтоогджээ.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

Даатгалын
компаниудын далд
луйврыг зогсооё

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Ашигтай ажилладаг учраас ББСБ-ын тоо жилээс жилд өссөн. Үүний сайн тал гэвэл тэдний зээлийн гэрээний нөхцөл жилээс жилд зөөлөрч, хүү нь ч буурах болсон. Харин мөнгөний эрэлд хатсан иргэдэд зээл олгох тухай сураг л дуудаж байвал нөхцөл ямар байх нь хамаагүй. Иргэдийн эл бачуурал даатгалынханд сул орж ирэх ашиг болж хувирсан байх юм. Тодруулж хэлбэл, иргэд тээврийн хэрэгслээ зээл авах ББСБ-ын нэр дээр шилжүүлэх учиртай. Нэр шилжүүлэх процесс явагдах үед тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгалыг шинээр хийлгэх шаардлагыг даатгалын компаниуд тавьдаг. Уг тээврийн хэрэгсэл өмнө нь бүх даатгалаа хийлгэчихсэн, дуусах хугацаа болоогүй эсэх нь даатгалынханд ер хамаагүй, шинээр гэрээ хийхийг л шаарддаг. Хэдхэн төгрөгийн зээл авах гэж байгаа ганц хөрөнгөө барьцаанд тавихаар явж байгаа иргэнд даатгалд төлөх илүүдээ гарсан мөнгө байхгүй нь ойлгомжтой. Ийн эсэргүүцэх нэгдэл даатгалын компаниуд үлдсэн хугацааны даатгалын зөрүү мөнгийг авч болно хэмээдэг ч ачир дээрээ ямар нэг байдлаар шалтаг тоочоор хоног авдаг. Тэгээд амьдрал дээр даатгалынхаа зөрүүг авсан иргэд хэд байдаг бол. Ихэнх иргэд бүрдүүлэх материал, явдал суудлаас нь төвөгшөөн хаях нь бий. Нөгөөтэйгүүр, даатгалынхан иргэдийн амь нас, эрүүл мэнд, эмчилгээ, гэнэтийн осол, үл хөдлөх хөрөнгө, агаарын хөлийн даатгалыг хийхдээ хөлд нь суух шахан наалддаг атлаа ядарч зүдрэн даатгал хэрэг болох цагт дор хаяж, гурав түүнээс дээш хоног нааш цааш гүйлгэдэг. Ялангуяа, эмчилгээний даатгалыг эргүүлж авах гэж иргэд үйл тамаа үздэг. Амь насаа алдсан тохиолдолд ар гэрийнхэн нь даатгалыг нь авах гэж явдаг ч үгүй. Өөд бологсдынхоо ясыг өндөлзүүлэхгүй гэсэн монгол араншин ч нөлөөлдөг биз. Уг нь авч чадсан юм өгөхдөө гар татдаггүй байвал иргэд даатгалын компанид итгэл үзүүлэн амь нас, эрүүл мэнд, үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслээ дуртайяа даатгана. Нөгөөтэйгүүр, холбогдох хуульд зааснаар бол иргэд сайн дурын үндсэн дээр даатгалд хамрагдах ёстой юм билээ. Гэвч амьдрал дээр юун сайн дур. Замын цагдаагийн дарамт, торгууль, оноо нь хасагдахаас айхдаа даатгуулдаг. Шинээр тээврийн хэрэгсэл худалдаж авсан иргэд авто машиныхаа гэрчилгээг авч, замын хөдөлгөөнд оролцохын тулд даатгалд хамрагддаг. Даатгалд хамрагдаагүй тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцоно гэдэг бүтэшгүй зүйл. Алхам тутамд цагдаа зогсоож явуулахгүй. Энэ бүхнээс харахад даатгалыг хүчинд автагдахын цагт гэж хэлж болно. Шулуухан хэлэхэд, даатгалын компаниуд бүгд хувийнх. Тэдний эзэд ардаа давхар эзэнтэй. Тэд нь танил тал, нэр нүүрээ ашиглан даатгалын компаниа ашигтай ажиллуулахын тулд чадах бүхнээ хийдэг. Тамирчид гэхэд л агаарын хөлийн болон амь насны даатгал хийгддэггүй бол онгоцны тийээ авч чадахгүй. Энэ мэтчилэнгээр иргэд үйл тамаа үзэж, тэр хэрээр даатгалын компаниудын данс цулайдаг тогтолцоог өөрчлөх цаг болжээ.

ХАВРЫН УЛС ТӨР ХАЛУУЦУУЛЖ ЭХЭЛЛЭЭ



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

МАН дотоод асуудлаа даравч далдайна, булавч бултайна

Үеийн үед эв нэгдэлтэй гэдгээ давуу тал болгож байсан МАН сүүлийн үед дотроо нэлээд сөргөлдөх боллоо. Уг нь тэднийг ард түмэн эв нэгдэлтэй гэдэг үндэслэлээр сонгосон. Учир нь АН өнгөрсөн дөрвөн жилд хоорондоо багагүй толжилсон учраас дотоод эв нэгдэлд иргэд илүү ач холбогдол өгсөн гэдэг дүгнэлтийг ч олон хүн хийгээд буй. Тэгвэл өнөөх эв нэгдлийн туйл болсон МАН-ынхан дотроо хагаралдаж эхэллээ. Тэдэнд утаас хагаралдах шалтгаан ч их бий. Юуны өмнө намын даргын шийдвэрүүд олон хүнд таалагдахгүй байгаа. Тэр дундаа намын ахмадуудад бүр ч таалагдахгүй байгаа гэх. Залуучууд дунд ч гэсэн намын даргын гаргаж буй шийдвэрт эгдүүцэж, эсэргүүцэж, бага сага улс төр хийж байгаа хүмүүс ч бас байна. УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр, Ц.Нямдорж зэрэг улстөрчдийн хийж буй улс төр ерөнхийдөө газар авч байгаа. Тэр дундаа Ц.Нямдорж гишүүн “Эрдэнэт” үйлдвэрийн асуудлаас эхлээд сүүлд үүссэн концессын гэрээг хүртэл нэлээд ондрийг нь авахуулж чадсан. Түүний хэлсэн үг бүрийг хүмүүс анхааралтай сонсч байна. Засгийн газрын янз бүрийн шийдвэрийг нэг намын нөхдөөс нь хамгийн их “алж” байгаа нь тэр. Түүнийг ингэж нам доторх асуудлаа хурцатгаж байгааг шударга загнаж байна гэж харах нэгэн байгаа байх.

Гэхдээ ихэнх нь Ерөнхийлөгчийн сонгуультай холбон тайлбарлаж байна. Ердөө сар гаруйн дараа ерөнхийлөгчийн ээлжит сонгууль болно. МАН-аас намын дарга М.Энхболд хэнтэй ч өрсөлдөхгүйгээр ногоон гэрлээр сонгуулийн эрхээ авна гэж байсан. Гэвч сүүлийн үед байдал өөр болчихоод байна. М.Энхболд дарга нэр дэвшихгүй ч байж магадгүй, цаагуураа өөр яриа хөөрөө болох ч магадлал бий болчихлоо. Дээрээс нь МАН-ын гишүүдээс хэд хэдэн хүн боломж хайж, МАХН руу очиж магадгүй гэсэн мэдээлэл гараад эхэллээ. Мэдээж бүгдээрээ боломж хайна гэж юу байх билээ. Зарим нэг нь Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх гэж намаа сольж болно. Харин ихэнх нь намын дотоод хагарлаас үүдэж байж ч болох. Тэгээд ч МАН дотроо нэлээд асуудалтай байгаа нь үнэн. Увсын хоёр гэхэд хоорондоо нэлээд тунжин хагарч, асуудал сүрхий томорсон талаар жиг жуг яваад л байгаа. Нөгөө талдаа МАН ард түмнийг жаргаана, асуудлыг шийднэ гэж гарч ирчихээд иргэдийн халаасыг сэгсэрсэн шийдвэр гаргаж байгаа нь олон гишүүнд таалагдахгүй байгаа. Түүнийгээ ч илэрхийлж буй. Яг хурал, чуулган дээр олонхи нь товчлуураа нэг саналд дарж байгаа ч илт эсэргүүцэгчид байгаа. Хамгийн сүүлд Ерөнхий сайд “Та нар улс төрөө хий, би ажлаа хийнэ” гэх мэтээр намынхандаа хаягласан шинжтэй үг бичсэн нь энэ намын дотоод хагарал даравч далдайж, булавч бултайж эхэлсний шинж биз ээ. Ядаж байхад хагарлыг нь нэмэх шалтаг олон байна. Ерөнхийлөгчийн сонгуулиас эхлээд.

АН-ынхан аанай л “алалдсаар”

АН-ынхан дотоод ардчилал гэж өөрсдийнхөө толжилцооныг тайлбарласаар, алалдсаар л өнөөг хүртэл. Тэд намаа шинэчилнэ, нэгэн цул болно, олон фракцийг ор мөргүй арилгана гэж байлаа. Улмаар намын шинэчлэлээ даргаа бүх гишүүдийн саналаар тодруулахаас эхэлсэн. Намын даргын сунгаанд таван хүн өрсөлдсөн, хөдөө, хотгүй л явсан. Бие биеэ баахан муулсан. Ер нь бол намын даргын сунгаа шинэчлэлгээсээ илүүтэй намыг тав хуваасан л хэрэг болсон. Гэхдээ цэвэрхэн өрсөлдөөд, ялагдлаа хүлээн зөвшөөрнө гэсэн болохоор дараа нь хэл ам нэг их гаргаагүй байх. Ганц авах юм нь тэр л байлаа. Одоо тэгээд юу өөрчлөгдөж, дээрдэв. Хамгийн сул сөрөг хүчин гэгдээд л явж байна. УИХ-ын гишүүдээс З.Нарантуяа, Д.Эрдэнэбат хоёр л арай дөнгүүр байгаа. Бусад нь сураггүй. Тэр ч битгий хэл намын даргын сонгууль хийж, АН-ыг тав хуваасан тэд дараа нь дахиад л баахан бужигналдав. Намын дотоод сонгууль хийж байна гэж 300, 400 хуваагдсан. Дотоод сонгуулийнхаа өмнө оффшортой холбоотой асуудлаар баахан бие бие рүүгээ дайрсан. Бас л бөөн хэрүүд, хараал. Мөнгө төгрөг хураасан нь буруу гэсэн байр суурьтай хэсэг бүлэг гарч ирээд л асуудал үүсгэсэн. Дахиад л баахан толжилцоон. Одоо Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчээ яаж тодруулах эсэх нь тодорхой биш байна. Бас л 6, 7 хүн Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрх авахын төлөө нам дотроо үзэлшлэнэ гээд байгаа. Аль хэдийнэ Ерөнхийлөгчийн

сонгуульд дотооддоо өрсөлдөнө гэж мэдэгдсэн хүмүүсээ “алаад” эхэлсэн. Аль эрт улирсан баларсан үүх түүхийг нь сөхөж, харлуулах гэж ядаж байна. Ядаж байхад яргчээр Б.Жаргалсайхан гэдэг нөхөр хүртэл АН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөнө гээд олны хажуугаар чихэлдээд явж байна. Дахиад л АН 5-6 хуваагдаж, нэг хэсэгтээ л бие биеэ муулах нь. АН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх хүн ирэх сарын эхээр тодрох байх. Уг нь дахиад сонгууль явуулна гээд байсан чинь одоо болохоор УБХ-гоор шийднэ гээд байгаа. Гэхдээ хоёр л хүний нэрийг УБХ-д өргөн барьж, тэндээсээ шалгаруулах сураг гараад байна. Түүнээс өмнө сонгуульд хүч үзэх гээд байгаа бяр нь амтагдсан 5, 6 хүнээ яаж зохицуулах юм бол гэдэг л сонин. Хэн хоёр хүний нэрийг сонгох вэ. Хасагдсан хэд нь Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдийн нэр албан ёсоор тодортол жинхэнэ халуухан улс төр хийнэ дээ. АН-ын алалдсаар, цаашид ч алалдана.

МАХН хэнийг Ерөнхийлөгчийн сонгуульд сойх вэ

Одоо бол МАХН-д хэнийг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх вэ гэдэг л хамгийн том асуудал болчихоод байна. Түүний хажуугаар УИХ-ын гишүүн О.Баасанхүү ялх шалхгүй улс төр хийж, өөрийнхөө байгааг сануулсаар. Түүний хийж буй үйлдлүүд бүгдэд таалагдах албагүй. Хамгийн гол нь тэр МАХН гэж нэг нам УИХ-д суудалтай байгаа шүү гэдгийг

мэдрүүлэх, мартагнуулахгүйн тулд бүхнийг хийж чадаж байна. Ерөнхийдөө өөрийгөө жаахан үнэд оруулахын хажуугаар намаас өгсөн даалгаврын дагуу ажиллаж байж ч болох. Дээрээс нь МАХН руу МАН-ын зарим гишүүд “урвах” гэж байгаа талаар яриа ч газар авлаа. УИХ-ын гишүүн О.Баасанхүү “Манай намд зургаан гишүүн элсэнэ” гэж ярьсан. Үүнтэй холбоотойгоор хэн хэн МАХН руу явах вэ гэдэг асуулт ч урган гарч ирж, хэвлэлүүд бүр нэрийг нь хүртэл таамаглаж эхэллээ. Тухайлбал, Ц.Нямдорж, Х.Болорчулуун, Ж.Энхбаяр, Т.Аюурсайхан, Ч.Хүрэлбаатар гэх мэт гишүүдийн нэр таамагт багтаж эхэлсэн. Тэр дундаас Ж.Энхбаяр өөрийнх нь нэрийг энэ мэт ховд хутгасанд багагүй ундууцаж байгаагаа илэрхийлсэн байсан. Мэдээж энэ бол таамаг, жиг жуг. О.Баасанхүү гишүүн зүгээр л улс төр хийж, хөөрхөн хөдөлгөөн оруулсан ч байж болох. Гэхдээ МАХН-д бол Ерөнхийлөгчийн сонгуульд хүчтэй өрсөлдөхүйц хүн хэрэгтэй байгаа. Тийм болохоор МАН-аас тийм боломж хайсан ганц хоёр хүн Н.Энхбаяр даргатай бага сага яриа хийсэн ч байж болох. Гэхдээ МАХН-аас Гадаад хэргийн сайд асан Л.Эрдэнэчулуун нэр дэвшиж магадгүй гэсэн яриа цухалзах боллоо. Гэхдээ энэ бол эхний ээлжний л “бор шувуу”. Ямар ч байсан МАХН энэ хаврын улс төрөөс мултарч үлдэхгүй. Адилхан халалцах нь тодорхой байна. Харин үнэхээр МАН-аас тэр зүгт гишүүд явах уу гэдэг л сонин байна. Хэрвээ үнэхээр Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх боломж хайсан ганц хоёр хүн явлаа гэхэд бас л халуухан юм болох нь дамжиггүй.

ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

Монгол Улсад суугаа Бүгд Найрамдах Энэтхэг улсын Элчин сайд Монгол Улсын Шадар Сайд, эрхэмсэг ноён У.Хүрэлсүхтэй 2017 оны дөрөвдүгээр сарын 21-нд уулзлаа. Уулзалтын үеэр Элчин сайд хатуу, хүйтэн өвөлд өртсөн Монголын малчдын гэр бүлд зориулж 20 мянган ам.долларын тусламж үзүүлэх болсноо Энэтхэгийн Засгийн газрын Гадаад хэргийн яамны нэрийн өмнөөс мэдэгдлээ. Уг тусламжийг Сүхбаатар аймгийн малчдын хүүхдүүд хүмүүждэг цэцэрлэгийг шинэчлэн тоноглоход зориулж, ойрын хугацаанд хүргэнэ. Энэхүү цаг үеэ олсон тусламж үзүүлж байгаад Монгол Улсын Шадар Сайд гүн талархлаа Энэтхэгийн Засгийн газарт илэрхийллээ.



PRESS RELEASE

The Ambassador of India to Mongolia met H.E. Mr. U. Khurelsukh, the Deputy Prime Minister, on 21 April 2017. During the meeting, the Ambassador on behalf of the Ministry of External Affairs, Government of India has offered US\$ 20,000/- relief assistance to families of Mongolian herders severely affected by the harsh winter and freezing temperatures recently. The assistance will be delivered shortly in the form of renovation and refurbishing of kindergarten meant for children of herders living in Sukhbaatar Aimag. The Deputy Prime Minister of Mongolia has conveyed his gratitude to the Government of India for this timely assistance.

ДЭЛХИЙ

БНСУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИД ХАЛЗ МЭТГЭЛЦЛЭЭ



БНСУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль ирэх сарын 9-нд болох билээ. Тус сонгуульд нийтдээ 15 нэр дэвшигч өрсөлдөж буй бөгөөд тэднээс хамгийн рейтинг өндөртэй, гол таван улс төрийн хүчний төлөөлөл энэ сарын 23-нд телевизийн халз мэтгэлцээнд оролцожээ.

Тэгвэл тус сонгуульд хамгийн рейтинг өндөртэй яваа Ардчилсан намын Мүүн Жэ Ин, Ардын намын Ан Чол Су нар Солонгосын хойгийн нөхцөл байдал, пуужин эсэргүүцэгч ТНААД системтэй холбоотойгоор ширүүн мэтгэлцээн өрнүүлсэн байна.

Мүүн Жэ Ин мэтгэлцээний үеэр “Хойд Солонгосын цөмийн хөтөлбөрийн өдөөн хатгалга үргэлжилсээр байна. Зэвсэг техникийнх нь ч хүчин чадал, технологи нь улам нарийссаар байхад Хван Кё Ан, Пак Гын Хэгийн засаглалын аль аль нь ямар ч дорвитой үйл ажиллагаа хэрэгжүүлж чадсангүй” хэмээн шүүмжлээд амжжээ. Түүнчлэн, “Олон улсын дипломат

харилцааг хүндэтгэж, БНАСАУ-д цөмийн хөтөлбөрөө бүрэн хөгжүүлж, Өмнөд болон Хойд Солонгосын харилцаанд эргэлт гаргаж чадна гэдэгтэй итгэлтэй байгаа”-гаа энэ үеэр онцлон тэмдэглэжээ. Харин дэмжигчдийнхээ тоогоор эдүгээ хоёрдугаарт эрэмбэлэгдэж буй “Ардын нам”-ын Ан Чол Су АНУ-ын армийн хамгийн сүүлийн үеийн Пуужингийн довтолгооноос эсэргүүцэн хамгаалах систем болох “ТНААД”-ийг дэмжсэн байр суурьтай байгаагаа илэрхийлж, “Тус системийг байрлуулахыг эсэргүүцэж байсан намын албан ёсны байр суурь өөрчлөгдсөн” гэж мэдэгдсэн байна. Харин үүнийг эсэргүүцэгч буюу пуужингийн довтолгооноос хамгаалах систем байрлуулах эсэхийг дараагийн Засгийн газар шийдэх ёстой гэсэн байр суурьтай байгаагаа өмнө нь тодорхой илэрхийлж байсан Мүүн Жэ Ин “Ардын нам ТНААД систем байрлуулахыг хүчтэй эсэргүүцэж байсан

...Сонгуулийн төв хорооноос ирэх сарын 9-ний өдрийг хүртэл нийтдээ гурван удаагийн халз мэтгэлцээнийг нэр дэвшигчдийн дунд зохион байгуулна. Харин энэ удаагийнх нь хамгийн эхнийх нь бөгөөд нэр дэвшигчид улс төр, гадаад бодлогынхоо талаар санал солилцжээ...

атлаа Ерөнхийлөгчид нэр дэвшигчийнхээ үзэмжээр байр сууриа өөрчилжээ. Тэгвэл

тус системийг эсэргүүцэж байгаа БНХАУ-ыг хэрхэн ятгах вэ” хэмээн эргэлзсэн өнгө аястайгаар харилцсан байна.

Сонгуулийн төв хорооноос ирэх сарын 9-ний өдрийг хүртэл нийтдээ гурван удаагийн халз мэтгэлцээнийг нэр дэвшигчдийн дунд зохион байгуулна. Харин энэ удаагийнх нь хамгийн эхнийх нь бөгөөд нэр дэвшигчид улс төр, гадаад бодлогынхоо талаар санал солилцжээ. Түүнчлэн ирэх баасан гарагт болох хоёр дахь удаагийн мэтгэлцээнээр эдийн засгийн асуудал, тавдугаар сарын 2-нд нийгмийн асуудлын талаар тус тус мэтгэлцэх юм байна. Ажиглагчдын үзэж буйгаар энэ удаагийн сонгуулийн гол өрсөлдөөн Ардын нам болон Ардчилсан намаас нэр дэвшигчдийн хооронд өрнөх аж. Хамгийн сүүлийн үеийн санал асуулгад оролцогчдын ойролцоогоор 80 орчим хувь нь тэднийг дэмжихээ илэрхийлжээ.

ОХУ ЦЭРГИЙН ТӨСВӨӨ НЭМЖЭЭ

ОХУ цэргийн төсвөө эдийн засгийн хүндрэлтэй нүүр тулсан ч, тодорхой хувиар нэмэгдүүлсэн тухай Шведийн Стокгольмын хүрээлэн тайландаа дурьджээ. Ингэснээр тус улс дэлхийд цэргийн төсвийнхөө хэмжээгээр гуравдугаарт бичигдэж байна.

“SIPRI” –ын мэдээлснээр ОХУ-ын 2016 оны цэргийн төсөв өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 5.9 хувиар их буюу 69.2 тэрбум ам.долларт хүргэж, ДНБ-д эзлэх хувийг хуучин ЗХУ нуран унаснаас хойшхи хамгийн өндөр төвшинд хүргэсэн байна. Тайланд “ОХУ-ын эдийн засгийн өсөлт газрын тос, байгалийн хийн үнийн уналт, Украины зүүн этгээдийн нөхцөл байдалтай холбоотой барууны орнуудаас тус улсын хориг арга хэмжээний улмаас буурсан. Гэвч энэ үед цэргийн төсвөө нэмэгдүүлсэн нь эдийн засагт том дарамт болсон” тухай “SIPRI” онцолжээ.

2015 онд Саудын Араб цэргийн төсвийнхөө хэмжээгээр дэлхийд гуравдугаарт бичигдэж байжээ. Харин 2016 онд тус улс бүс нутагт үймээн самуун үргэлжилсээр байсан ч, цэргийн төсвөө өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 30 хувиар бууруулж, 63.7 тэрбум ам.долларт хүргэснээр нэг байр ухарч, дөрөвдүгээрт эрэмбэлэгдэх болсон байна.

АНУ, БНХАУ батлан хамгаалах салбарт зарцуулсан зардлаараа дэлхийд нэг, хоёрдугаарт бичигдэж байна. 2016 онд АНУ төсвөө 1.7 хувиар нэмэгдүүлж, 611 тэрбум ам.доллар болгосон бол БНХАУ 215 тэрбум ам.долларыг төсөвлөжээ. Гэхдээ БНХАУ-ын тухайд өмнөхөөсөө 5.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Дэлхий нийтээр авч үзвэл улс орнууд батлан хамгаалах зардалд нийтдээ 1686 тэрбум ам.долларыг өнгөрсөн онд зарцуулсан нь дэлхийн ДНБ-ий 2.2 хувь болжээ.

Афганистаны Батлан хамгаалахын сайд огцорлоо

Талибан бүлэглэлийн хоёр толгойлогчийг устгасны хариуд Афганистаны хойд хэсгийн армийн бааз руу зэвсэгт этгээдүүд дайралт хийжээ. Халдлагын улмаас 100 гаруй хүн амь үрэгдсэн байна. Афганистаны Засгийн газрыг дэмжигч хүчин Кундуз болон Багхлан муж дахь Талибан бүлэглэлийн хоёр толгойлогчийг устгасан аж. Үүний хариуд Талибан бүлэглэл Афганистаны хөгжингүй, олон хүн амтай Мазар-э Шариф хотын ойролцоох цэргийн хуаран руу дайралт хийжээ. Цэргийнхний хувцсаар халхавчилсан Талибаны зэвсэгт дайчид армийн бааз

руу дайрч, зургаан цагийн турш буудалцаан үргэлжилсний эцэст, тус улсын 138 цэрэг амь үрэгдсэн тухай албаны эх сурвалжууд мэдээлж байсан юм. Тэгвэл энэхүү үйл явдалтай холбоотойгоор Афганистаны Батлан хамгаалахын сайд, штабын даргынхаа хамт албан тушаалаасаа огцорчээ. Афганистаны Батлан хамгаалахын сайд Абдуллах Хабиби, Үндэсний армийн штабын дарга Кадам Шах Шахим нар өчигдөр албан ёсоор үүрэгт албанаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргаж, Ерөнхийлөгч Гани хүлээн авсан байна. Афганистанд АНУ-ын 8400, НАТО-гийн 6000 цэрэг үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Р.АМАРЖАРГАЛ, Н.БАТБАЯР, Б.ГАРАМГАЙБААТАР НАРЫН “ТОМ МӨРӨӨДӨЛ”

С.НЭМЭХ

Ардчилсан намын аль ч фракцид хамаарагдаггүй, харьяалагддаггүй хэмээн өөрийгөө тодорхойлдог эрхэм бол Р.Амаржаргал. Гэхдээ улс төрийн удам судрыг нь хөөгөөд үзвэл “МҮДН”-ээс гаралтай. “МҮДН”-ийн “Фортуна” Н.Батбаяр, “Монроуд” Д.Гарамгайбаатар хоёртой Р.Амаржаргалыг үй зайгүй гэх. Тиймээс Р.Амаржаргалыг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээр горлоход нь уухайлан дэмжиж, уулгалан боссон хүмүүс бол “Фортуна” Н.Батбаяр, “Монроуд”-ын Б.Гарамгайбаатар нар юм. Түүнийг Ерөнхийлөгч болбол “Фортуна” Н.Батбаяр нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, “Монроуд” Б.Гарамгайбаатар нь ахлах зөвлөхийн сэнтийг сэрүүн зүүдэлж, сэмхэн мөрөөдөж яваа сураг чих дэлсэх болов. Байж болох л хувилбар. Харамсалтай нь Монголын төр гэмт хэрэгтнүүдийн орогнох газар биш гэдгийг Р.Амаржаргалыг тойрон хүрээлсэн хоёр эрхэм ойлгоогүй, ухаараагүй яваа нь маш том эмгэнэл.

Зүй нь, “Фортуна” Н.Батбаяр УИХ-ын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайдаар ажиллаж байхдаа юу хийж гийгүүлсэн бэ?

Хөгжлийн банкныг хувийн өмч шиг санаж, бондын мөнгийг өөрийн хөрөнгө шиг зарцуулсныхаа горьг одоо тэрбээр амсаж яваа. Бүр цааш нь ухвал Хөгжлийн банкны шороотойгоо хутгалдсан нэрхүнд нь түүнтэй шууд хамаарна. “Өр” гэдэг үгийг “Өглөг” гэдэг үгээр солиод монгол өргүй болох ухаан цор ганц түүнээс л гарна. Ямар сайндаа л УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар тухайн үед гайхшаа барж байх вэ дээ. Тэрбээр “Н.Батбаяр аа чи ер нь нэг эмнэлэгт үзүүлбэл яасан юм бэ. Эсвэл “Чингис” бондыг “Н.Батбаяр бонд” гээд нэрлэхийг” хэмээн ярьж суусан. Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийн Ерөнхий сайд болох зам тэртээ 1980-аад оны үед засагдсан байсныг ганцхан

“Фортуна” Н.Батбаяр л олж мэдсэн. Учир нь Н.Алтанхуя нэрээ Н.Алтанхуяг болгож сольсноор Ерөнхий сайд болчихсон гаргалгааг “Фортуна”-гаас өөр хэн ч ухааж ойлгохгүй нь гайхамшигтай. Р.Амаржаргал Ерөнхийлөгч болбол ийм л хүн Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллах болох нь. Тэрбээр төрийн ордонд “эргэн ирэлт” хийвэл дахиад л нөгөө тулган дахь галаа бадраах л байх даа.

Тэдний мөрөөдлөөр аль хэдийнэ Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх болсон Б.Гарамгайбаатар тэвгэл ямар хүн бэ?

Өнгөрсөн дөрвөн жил УИХ дахь АН-ын бүлгийн даргаар ажилласан тэрбээр төрсөн нутаг, өссөн голоо хувийн тойрог болгочих санаатай хүссэнээрээ зурсан ч МАН-ын нэг хүүхэд /Ц.Нямдоржийн хэлснээр/ түүнийг тонгорч орхисон. Өнөөдрийн байдлаар “Монроуд” компанийн бондтой холбогдсон хэргийн “ач”-аар АТТ-т шалгагдаж байгаа. Ер нь л түүний үүсгэн байгуулсан “Монроуд” компани нь бондын мөнгөнөөс их хэмжээгээр шамшигдуулсан нь тодорхой болсон. Энэ хар толбоо баллуурдахын тулд Р.Амаржаргалыг Ерөнхийлөгч болгож, түүний суганд хавчуулагдах сонирхол “Фортуна” Н.Батбаяр, “Монроуд” Д.Гарамгайбаатар хоёрт тун ч их байгаа нь ойлгомжтой. Яг ийм нөхцөл байдал үүсвэл Монгол Улсад, улс төрийн хүрээнд хариуцлага гэгч зүйл огт ор үгүй хоосон зүйл болж хувирна. Ард түмний хөөрсөн санаа тэжэж яваа нь ичих булчирхайгүй хүмүүсийн л үйлдэл юм даа...

Энэ гурвын “том мөрөөдөл” хаана очиж төгсөхийг хэн ч таашгүй.



Эммануэль Макрон, Ле Пен нар тунаж үлдэв

Францын Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёрдугаар шатанд Эдийн засгийн сайд асан Эммануэль Макрон, “Үндэсний фронт” намын Марин Ле Пен нар тунаж үлдлээ. Сонгуулийн шийдвэрлэх шатны санал хураалт ирэх сарын 7-нд болох юм.

Франц даяар нэгдүгээр шатны сонгуулийн санал хураалт өглөө 08.00 цагт эхэлж, оройн 20.00 цагт дуусгавар болж, санал тооллогын ажиллагаа албан ёсоор эхэлсэн байдаг. Тэгвэл саналын хуудасны 98 хувийг тоолсны дараах байдлаар Макрон 23.9 хувийн санал авсан бол сонгогчдын 21.4 хувь нь Ле Пенд итгэл хүлээлгэжээ. Харин Барууны төвч үзэлт Бүгд Найрамдах намаас нэр дэвшсэн, Ерөнхий сайд асан Франсуа Фийон 19.9 хувийн санал авсан бол Зүүний намын дарга асан Жан-Люком Меленхоном 19.6 хувийн санал авсан аж. “Үндэсний фронт” намаас нэр дэвшигч Марин Ле Пен хувьд хэрэв Ерөнхийлөгч

болбол Францыг ЕХ-оос гаргаж, цагаачлалын хатуу бодлого баримтална гэдгээ тодорхой илэрхийлсэн. Манай улсын 4500 орчим иргэн тус улсад сурч, хөдөлмөрлөдөг бөгөөд Марин Ле Пен ялалт байгуулсан тохиолдолд дээрх тоонд өөрчлөлт орж болзошгүй билээ. Учир нь түүний баримталж буй хоёр гол бодлогын нэг нь цагаачдыг хүлээн авахгүй байх, албадан гаргах бол нөгөө нь ЕХ-ноос Францыг гаргах юм. Үүнээс гадна түүний нэр хүнд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Д.Трамп ялалт байгуулсны дараа огцом өсч эхэлсэн байдаг. Харин Э.Макрон ЕХ-ны дүрмийг дагахаа мэдэгдээд буй. Гэхдээ зарим олон улс судлаачид Марин Ле Пен шийдвэрлэх шатанд тунаж үлдсэн ч Ерөнхийлөгч болохгүй болов уу гэсэн таамгийг дэвшүүлж байгаа юм. Тэдний үзэж буйгаар францчууд ЕХ-нд үлдэх, байр суурийг нь бэхжүүлэх сонголтыг хийх магадлалтай ажээ.

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос [Сүхбаатар аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дээврийн засварын ажил]-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д хандаж тендерийн бичиг баримтыг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг [2017 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 15 цаг 00 минут]-аас өмнө [Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д нэвтрэн орж

тендерийн материалаа /pdf файл/ цахим хэлбэрээр] ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан [2017 оны 05 дугаар сарын 01]-ны өдрийн [15 цаг 30 минут]-т нээнэ.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. (Ахлах мэргэжилтэн Ч.Батболд, Утас:96510404, 70518123)

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 3 давхар 306 тоот, Орон нутгийн өмчийн газар, ахлах мэргэжилтэн Ч.Батболд, утас 96510404

ОНЦЛОХ ХУУДАС

ҮНДСЭН ХУУЛИЙГ ӨӨРЧИЛНӨ, ӨӨРЧЛӨХГҮЙ

Эсрэг тэсрэг байр суурь

М.Билэгт:
Үндсэн хуулиа
өөрчлөх эсэх нь ард
түмний шийдвэр



/УИХ-ын гишүүн/

-Үндсэн хууль ч байр нь ямар нэг хууль тодорхой цаг хугацааны дараа баяжаад явж байдаг. Монгол Улс зах зээлд шилжээгүй байхад Үндсэн хуулийг баталж байсан улстөрчид хоёрдмол сэтгэлгүйгээр хууль баталж чадах төлөвшилтэй хүмүүс байсан. Тиймээс 1992 оны хууль маш сайн хууль болсон. Гэтэл дараа нь дордуулсан долоон өөрчлөлт оруулж байлаа. Түүн шиг алдаа гаргах вий гэсэн болгоомжлол байгаа. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хүмүүсийн оюун санаа асар их өөрчлөгдсөн. Нөгөө талаар ямар нэг зорилго, даалгавартай өөрчлөх талаар ярьж байгаа ч хүн бий. Зарим нь би ашиг сонирхлын зөрчилтэй нийм зүйл ярьж байна шүү гэдгээ мэддэггүй ч байх талтай. Гэхдээ ард түмнээс авах санал асуулга зөв голдрилоор яваасай гэж хүсч байна. Зарчимтай, шударга хийж чадвал ард түмэн бодит байдлыг хэлээд өгнө шүү дээ. Одоо яригдаж байгаа зургаан зүйл заалтаар санал асуулга явагдана. Мэдээж Ерөнхийлөгчийн засаглалтай байх, дээд доод парламентын тухай хүмүүс хэлж буй. Гэхдээ Ерөнхийлөгч гэдэг нэгхэн хүний дохио зангаагаар явах юм бол улс орон хаашаа явах вэ. Сүүлийн 10 гаруй жил бид харлаа, үзлээ. Монгол Улс цөөхөн хүн амтай. Нэг сая гаруй нь идэвхтэй хүн амтай шүү дээ. Гэтэл ганцхан хүний дохио зангаагаар явах юм бол энэ улс сүйрнэ. Хууль хүчний байгууллага ганцхан хүний дохио зангаагаар явахад юу болдог вэ гэдгийг бид харсан. Шүүхийг атгаж суучихаад тэрийг барьж хорь, ингэж шийдвэр гарга гээд суугаад байвал юу болох билээ. Тэгэхээр асуудлыг сайтар ярилцах ёстой юм. 76 гишүүнтэй байх нь зөв байх. Хариуцлага гэж байх ёстой. Сонгогчтойгоо уулзахын тулд тэд чинь харууцлагатай байна, ажлаа хийх болно. Дээд, доод парламенттай байх тухай санал зарим хүмүүс гаргаж л байна. Гэхдээ түүнийг нь ард түмэн шийддэг. Ямартай ч Ерөнхийлөгчийн засаглал гэдгийг би хувьдаа дэмжихгүй байгаа. Засгийн газрын гишүүн УИХ-ын гишүүнээр ажиллаж болно гэсэн заалтыг дордуулсан долоон өөрчлөлтөөр хийсэн. Гэтэл одоо энэ асуудлыг өөрчлөө гээд л явж байх жишээтэй.



Ё.Баатарбилэг: Үндсэн хуулийг өөрчлөхөөс
өөр гаргалгаа алга

/УИХ-ын гишүүн/

-Одоогийн парламент Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаас өөр гаргалгаа өнөөгийн нөхцөлд харагдахгүй байгаа нь худлаа биш. Парламентын гишүүдийн 4/3 нь дэмжсэн тохиолдолд Үндсэн хуульд өөрчлөлт оруулж болдог. Ийм өндөр хэмжээнд нэг зүг харж, асуудлаа хэлэлцэх тохироо тийм ч амархан бүрдэхгүй л дээ. Энэ ч утгаараа парламентад хэд хэдэн намын бүлэг байгаа нөхцөлд Үндсэн хуулийн өөрчлөлт ярих бараг л боломжгүй. Сүүлийн 10 гаруй жил яригдсан ч намуудын зөвшилцөл дээр л гацсан байдаг. Зөвлөлдөх санал асуулгын дүнгээр үнэхээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлага байна уу гэдэг нь тодорхой болох юм билээ. Гэхдээ Ерөнхийлөгчийн сонгуулиар Үндсэн хуульдаа яг ямар чиглэлд оруулахаа ард түмнээсээ дахин асуух юм билээ. Ингэснээр нийгмийн бүхий л хүрээнд асуудлыг нухацтай авч үзэж, холбогдох өөрчлөлтийг оруулах нөхцөл бүрдэнэ гэж харж байна.

Сэтгүүлчийн дүгнэлт

ҮНДСЭН ХУУЛЬ ӨӨРЧЛӨХ ЧАДВАРТАЙ ПАРЛАМЕНТ МӨН ҮҮ

Б.ӨНӨРТӨГТОХ

Үндсэн хуулиа өөрчлөх тухай яриа ганцхан өнөөдөр л яригдсан хэрэг биш. Үе үеийн УИХ энэ тухай ярьж байлаа. 2012 онд Үндсэн хуулийг өөрчлөх тухай ажлын хэсэг гарч, улмаар 2015 оны сүүлч, 2016 оны эхээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн мэдүүлж байв. Гэвч тэр үед УИХ-ын гишүүн Ц.Нямдорж тэргүүтэй улстөрчид эрс эсэргүүцэж, ийм завхарсан парламентаар Үндсэн хуулиа тоглуулахгүй, ард түмнээсээ асууж өөрчилнө хэмээсээр асуудлыг буцааж байсныг уншигч та санаж буй биз. Тэгвэл завхарсан биш парламент нь энэ юм байх. Өөрөөр хэлбэл, МАН-ын "65-ын бүдүүн бүлэг" Үндсэн хуулийг өөрчлөх санал асуулга явуулж, тогтолцооны өөрчлөлт хийх талаар ярьж эхлэв. Зөвлөлдөх санал асуулга гэсэн халхавчийн цаана юу нуугдаж буйг таахад эрт байна. Зөвлөлдөх санал асуулгыг 1570 гишүүнээс авах ажлын хэсэгт багтсан гишүүд энэ талаар хэвлэлд ам ангайхыг ч хүсэхгүй байх аж. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах нийгмийн хэрэгцээ шаардлага байгаа. Гэвч асуудлыг нэг нам дангаар, эсвэл хүч түрэн баталж боломгүй. Үндсэн хуулийн өөрчлөлт гэх гоё малгай өмсгөчихөөд цаана нь төрийн эргэлт хийх, эс бөгөөс албан тушаалд мөнх суух чин хүсэл агуулсан юм бий биз гэсэн нийгмийн хардлага ч нэгийг хэлээд байгаа юм.

Нөгөө талаар, Үндсэн хуульдаа Ерөнхийлөгчийн засаглалтай байх заалт оруулах тухай зарим хүмүүс ярьж эхэллээ. Туршлагатай хуульчийн амнаас ийм үг унаж байгааг бодоход энэ удаагийн Үндсэн хуулийн өөрчлөлт асар өргөн сэдвийг хамрах нь тодорхой байна. Нэг талаар энэ санал төдий боловч Монгол Улс нэг хүний дарангуйлалд орж огтхон ч болохгүй. М.Билэгт гишүүний хэлсэнчлэн хууль, шүүхийг нэг хүн атгавал энэ улсад юу болох билээ. Хэн дуртайгаа шүүхээр айлгаж, захиран зарцуулах эрх мэдэл нэг хүний гарт шилжих нь хэрхэвч байж боломгүй асуудал билээ. Тэгээд ч Ерөнхийлөгчийн засаглалтай байх тухай асуудлыг нэг хуульч яриад шийдчих хэрэг огтхон ч биш юм. Ерөнхийлөгчийн засаглалтай улс орнуудын улс төрийн тогтолцоо, алдаа оноо зэргийг нарийн сайн судалж байж шийдэх учиртай. Тухайлбал, Улс төр судлаач Ц.Мөнхцэцэгийн 2005 онд нийтлүүлж байсан "Ерөнхийлөгчийн засаглалын бараан сүүдэр" гэх нийтлэлд Монголд ийм засаглал байх хэрэгтэй эсэх цаашлаад ямар сул тал байдаг талаар бичсэн байдаг. Уг нийтлэлд "Ерөнхийлөгчийн засаглалын нэгэн сөрөг үр дагавар бол улс төрийн намын төлөвшилд сөргөөр нөлөөлж, хувь хүний үүрэг ролийг улс төрийн амьдралд чухал болгон хувиргадаг явдал юм.

Ялангуяа улс төрийн нам, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл зэрэг нийгмийн үндсэн институтуудын төлөвшилт сул байгаа нөхцөлд Ерөнхийлөгчийн хувийн үүрэг роль нийгэмд хүчтэй болдог. Ардчиллаас ухрах хийгээд ардчиллаас авторитар дэглэм рүү хийх шилжилтийн шалтгааныг судлаачид эдийн засгийн хөгжил, тухайн улсын хэмжээ, соёл, дайн дажин, харийн түрэмгийлэл, үзэл суртлын ялгарал, сонгуулийн тогтолцоо зэрэг олон хүчин зүйлтэй холбоон тайлбарлаж ирсэн хэдий ч посткоммунист улсуудад ажиглагдаж буй ухралтын үндсэн шалтгаан нь Ерөнхийлөгчийн засаглал, түүний эрх мэдлийн хэтийгдэл болжээ" хэмээн бичжээ. Тиймдээ ч нэг хүний дарангуйлал, эрх мэдлийн тэнцвэргүй байдал манайх шиг улс оронд огтхон ч нийцэхгүй гэдэг нь эндээс харагдаж байгаа юм. Үндсэн хуулийн өөрчлөлттэй уялдан яригдаж буй өөр нэг сэдэв бол дээд, доод парламенттай байх тухай асуудал. УИХ-ын 76 гишүүний эрх мэдэл хэмжээ хязгаараа алдаж, хэсэг бүлгийн эрх ашгаар төрийн ажил явж байна гэсэн шүүмжлэлтэй цаг үед 300 хүнээр парламент бүрдүүлэх нь эрүүл үзэгдэл байж мэдэх л юм. Өөрөөр хэлбэл, хууль тогтоох байгууллагад хяналт тогтох эрүүл үзэгдэл иргэдийн хяналтаар бий болох давуу тал байж мэдэх билээ. Парламент дээд, доод танхимтай боллоо гэхэд захын сумаас ч ард түмний төлөөлөл төрд суух боломж бүрдэнэ гэж үздэг.

Ингэснээр улстөрчдийн лобби, эрх мэдлийн төлөөх тэмцэл арилж, хяналт зөв тогтох давуу талтай гэдгийг олон ч улс төр судлаачид хэлжээ. Ер нь нэг хүнд эрх мэдлийг өгснөөс олонхийн төлөөлөлд хариуцлага үүрүүлэхэд буруудах юу байх билээ. Гэвч энэ бүхнийг хийх эсэх нь зөвхөн Зөвлөлдөх санал асуулгын дүнгээс шалтгаална. МАН-ын сонгож авсан 1570 хүн Үндсэн хуулиа өөрчилнө гэсэн санал өгвөл "эцэг" хуульдаа гар дүрэх эхний алхам хийгдэнэ. Улмаар өөрчлөх асуудал дараагийн шатанд яригдаж, ард нийтийн санал асуулгаар шийдэх учиртай билээ. Ардчилсан нийгэмд шилжсэн 27 жилийн хугацаанд Үндсэн хууль суурь зарчмаасаа хэзээ ч хазайгаагүй. Тухайн үед энэ хуулийг баталсан депутатууд тун чамбай хууль боловсруулсан гэдгийг бүгд хүлээн зөвшөөрдөг. Тиймээс Үндсэн хуулийн өөрчлөлтийг хамгийн чамбай, сайтар бэлтгэгдсэн хуульчдаас бүрдсэн парламент хийх учиртай билээ. Харин тэр шалгуурт өнөөгийн парламент тэнцэнэ гэж хэлэхэд эрт байна. Гишүүдийнх нь талаас илүү хувь нь шинэхэн, асуудлаа ойлгохгүй, хуулийн төсөл ч боловсруулж үзээгүй залуус байгаа учраас өөрчлөлт хийх цаг нь өнөөдөр биш гэдгийг сануулах нь илүүц биз.



О.Баасанхүү:
Ард түмний
анхаарлыг сарниулах
ТОГЛОЛТ

/УИХ-ын гишүүн/

-Тэтгэврийн нас нэмлээ, татвар нэмэгдлээ, Монгол Улс их хэмжээний өрөнд орлоо гээд аймшигтай асуудлууд ар араасаа цуварч байгаа. Тиймээс ч ард түмэн шийдвэр гаргаж байгаа хүмүүс рүү хамаг анхаарлаа хандуулах байна. Харин үүнийг нь боллуулахын тулд Улаанбаатарт байгаа төмөр замыг Богд уулын дундуур гаргая, Үндсэн хуулийг өөрчилнө гэж яриад эхэлсэн. Гэтэл хэвлэлийнхэн дархан цаазтай уул яагаад цоолох гэж байгаа юм, Үндсэн хуулийг яагаад өөрчлөх гэж байгаа юм, хоёр танхимтай эсвэл нэг танхимтай болох юм уу гэх мэтээр бужигнаад эхэллээ. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгчийн сонгуулийн үед Үндсэн хуулийг л яриулах тэдний өгөөшийг хэвлэлийнхэн үмхээд, улмаар ард иргэдийнхээ тархийг угааж байгаа хэрэг. Тиймээс энэ бол зүгээр л ярианы сэдвийн өгөөш юм. Үндсэн хуулийг өөрчлөх хуулийн дагуу ямар ч зүйл явагдаагүй, хэн ч байр сууриа нэгтгээгүй байгаа. Тиймээс энэ бүх зүйл бол зүгээр л ард түмний анхаарлыг сарниулахаар хийж байгаа "тоглолт" гэж хэлмээр байна. Үндсэн хуулийг өөрчилж болно. Гэхдээ Үндсэн хуулийг өөрчлөхийн тулд нэгдүгээрт нийгмийн язгуур болон суурь харилцаа өөрчлөгдсөн эсэх буюу эдийн засгийн болоод улс төрийн, оюун санааны харилцаа өөрчлөгдсөн үү гэдгийг бодолцох ёстой. Хэрвээ өөрчлөгдсөн бол суурь харилцаа нь хэрхэн өөрчлөгдсөн бэ гэдэг судалгаанд үндэслэл, судалгаатай, баримттай ярьдаг юм. Түүнээс биш хаанаас тодорсон нь тодорхойгүй Г.Занданшатар мэргийн хүн гарч ирээд ард түмнээс санал асуулга авч байна гэж бужигнуулаад, сүүлдээ хувьсгал болгочих вий гэж би санаа зовж байна. Үндсэн хуулиа өөрчлөх, Үндсэн хуулийн хувьсгал хоёр чинь ялгаатай зүйл шүү дээ.



Д.Мурат: Өөрчлөхөд цаг хугацаа хэрэгтэй,
одоо цаг нь биш

/УИХ-ын гишүүн/

-Үндсэн хуулийг өөрчлөх нийгмийн захиалга, хэрэгцээ байгаа юу гэвэл бий. Гэхдээ нэг нам дангаар үнэмлэхүй олонхи бүрдүүлсэн үед хуульд өөрчлөлт оруулах хэрэггүй байх. Парламентад суудалтай улс төрийн намууд зөвшилцөж байж зөв шийдэл гарна гэж боддог. Тиймээс өөрчлөх цаг нь өнөөдөр биш л гэж хэлмээр байна. Үндсэн хуульд өөрчлөлт оруулахтай холбоотой олон ч хүмүүс байр сууриа илэрхийлж байна. Ерөнхийлөгчийн засаглалтай болох нь зөв гэж үзэх хэсэг байхад нөгөө талд Ардын их хурал буюу дээд, доод танхимтай болох тухай ярьж байна. Энэ бүх өөрчлөлтийг хийх боломж бидэнд байсан уу гэвэл байна. Харамсалтай нь хийж чадаагүй. Ерөнхийлөгчийн засаглалтай болгоё гэж яриад л хийчих зүйл биш л дээ. Тооцоо судалгаатай байх хэрэгтэй. Ийм боломж байхад хийж чадаагүй юм чинь одоо яриад яах билээ. Миний хувьд дээд, доод парламенттай байх асуудлыг буруу гэж боддоггүй. Ард иргэдийн төлөөлөл орж ирээд хяналтаа тавиад, олонхийн хяналттай гэдэг үүднээс болохгүй зүйл алга. Гэхдээ дахиад хэлэхэд, дээд, доод танхимтай байх өөрчлөлт хийх боломж байсан шүү дээ. Гэтэл бас л хийж чадаагүй. Зах зээлийн нийгэмд шилжихээс өмнө одоо яриад байгаа өөрчлөлтөө хийх боломж байсан шүү дээ. Гэтэл өөрчилж чадаагүй өнөөдрийг хүрсэн. Нэг нам хүч түрж асуудлыг оруулах нь буруу гэж бодож байна. Өөрчлөх хугацаа нь өнөөдөр биш л гэж хэлбэ.

ОРОН НУТАГ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

С.БАЯСТАЛАН: ХӨРӨНГӨ ЦААНА ХАРИУЦЛАГА БАЙХ



ДОРНОГОВЬ АЙМАГ

Хөрөнгө оруулалтаар их бүтээн байгуулалтын ажлууд хийгдэнэ

Дорноговь аймаг болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрэн хот хоорондын найрамдалт хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрэн хотын хөрөнгө оруулалтаар Сайншанд хотын "Алтанговь худалдааны төв"-ийн гадна гудамж талбайг бүрэн шинэчлэх, аймгийн төвийн 5.4 км замын дагуух 165 ширхэг хос гэрэлтүүлгийг шинэчлэх, аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүлээлгийн танхимын өргөтгөл засварын ажлыг тус хотын инженер техникийн ажилчид ирж хийж өгөхөөр болсон. Тус ажлын хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрэн хотын Бүтээн байгуулалтын газрын дарга Пан Го Юнь болон гүйцэтгэгч БНХАУ-ын Бээжин хотын "ИЦай" компанийн захирал Тан Пан тэргүүтэй ажлын хэсэг Сайншанд суманд айлчилж, бүтээн байгуулалт хийгдэх ажлуудтай газар дээр нь танилцсан бөгөөд аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин тус бүтээн байгуулалтын ажлууд товчлон хугацаанд хөдөлмөр аюулгүй байдлыг сахин ажиллаж, чанарын өндөр төвшний гүйцэтгэлтэй хүлээлгэж өгөхийг хүссэн юм. Мөн Дорноговь аймгийн бүтээн байгуулалтад томоохон хөрөнгө оруулалт хийж байгаад нэн түрүүнд талархал илэрхийлж, цаашдын ажил үйлсэд амжилт хүссэн юм.

ОРХОН АЙМАГ

"Өрхийн тариалан 2017" төсөл хэрэгжүүлнэ

Орхон аймгийн ХХААГ "Өрхийн тариалан 2017" төсөл боловсруулсанаа орон нутгийн удирдлагуудад танилцууллаа. Тус аймаг 5000 гаруй га газар тариалангийн эргэлтийн талбайтай. Үүний 100 хувьд тариалалт хийж, га-аас авах ургацын хэмжээ улсын дунджаас дээгүүр байдаг ч төмс, хүнсний ногооны хэрэгцээгээ бүрэн хангаж чадахгүй байгаа юм. Тиймээс "Өрхийн тариалан 2017" төсөл хэрэгжүүлж хамгаалагдсан хөрсний аж ахуй буюу хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, орон нутгийн онцлогт тохирсон гүйцэд боловсордог богино сортын үрээр тариаланчдыг хангах, иргэдийн өмчилж авсан хашааны газарт өрхийн тариалант хөгжүүлэхээр болжээ. Мөн "Өрхийн тариалан 2017" төслийг гурван чиглэлд хэрэгжүүлэхээр боловсруулсан байна. Тухайлбал, Атрын III аяны хүрээнд "Тариалан эрхлэлтийг дэмжих сан"-гаас нийт 2400 м.кв 30 ширхэг хүлэмжийг тариаланчдад хөнгөлөлттэй үнээр олгох, сумдад "Агро үйлчилгээний төв" байгуулах замаар техник үйлчилгээг нэвтрүүлэх, өрхийн тариалант хөгжүүлэх ажлыг төслийн хүрээнд хийхээр төвлөжээ. Мөн төслийн хүрээнд 1000 айлыг хамруулж, тоног төхөөрөмжөөр хангах бөгөөд нийт 211.4 сая төгрөг зарцуулахаар тооцсон гэж ХХААГ-ын дарга Ж.Бат-Өлзий хэллээ.

СЭЛЭНГЭ АЙМАГ

Сэлэнгэд бүх нийтийн цэвэрлэгээ боллоо

Сэлэнгэ аймгийн иргэд Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд тусгагдсан "Байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг" хэмээн заасныг биелүүлж, бүх нийтийн цэвэрлэгээг өнгөрөгч амралтын өдрүүдэд зохион байгууллаа. Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлагдсан, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Манай гудамж-Миний гэр" хөтөлбөрийн хүрээнд "Цэвэр орчин-Эрүүл амьдрал" аяны хүрээнд зохион байгуулагдсан бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлын нээлтийн үеэр аймгийн Засаг дарга Ш.Оргил Сүхбаатар сумын ТҮГ-ын ажилчдад ажалдан хувцас бэлэглэлээ. Мөн эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа тохижилт үйлчилгээний байгууллагуудын гурван ажилтан, хашаа хороогоо үлгэр жишээ тохижуулсан Сүхбаатар сумын гурван иргэнийг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнаж урамшуулав. Энэ удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээний ажилд аймгийн төвийн төр төсөв, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн 102 байгууллага хамрагдан хуваарийн дагуух газруудаа цэвэрлэж их хотынхоо 80 жилийн ойд бэлэг барьсан юм. Мөн Сүхбаатар сум дотор үйлчилгээ үзүүлдэг бага оврын ачааны машины 12 жолооч, хог тээвэрлэх гэрээ байгуулан ажиллалаа. Энэ өдөр Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил Сүхбаатар сумын 1-р багийн нутаг дэвсгэр дээр байрлах хог хаях төв цэг дээр очиж бодит байдалтай танилцсан юм.

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Мөн нийтийн орон сууцны байрнуудын нөхцлийг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

"Тэр нь ямар хөтөлбөр вэ?"
"Миний гэр-Манай байр" аймгийн дэд хөтөлбөрийг боловсуулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд Дархан сумын Өргөө, 4, 9, 10, 12, 14, 16 дугаар багийн нийтийн орон сууцны орчны 65 ш хаалга, Шарын гол сумын нийтийн орон сууцны орчны 30 ш кодтой, дулаалагатай, соронзон зүрхэвч бүхий төмөр хаалгыг 98.1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төвлөвөд байна. Мөн Дархан сумын 11 дүгээр багийн өсдүгээр байрны дээвэр, 10 дугаар байрны иженерийн шугам сүлжээг 42.0 сая төгрөг шинэчилж засварлана. Ер нь нийтийн орон сууцны дээвэр засварын ажилд 30.0 сая төгрөг зарцуулна. Дархан сумын 13, 14, 16 дугаар багийн нутаг дэвсгэрийг бүрэн камерийн системд шилжүүлэх ажлыг 40.0 сая төгрөгөөр хийнэ. Улмаар 27.0 сая төгрөгөөр Дархан сумын 18-н хэсгийн байцаагч нарт зөврийн компьютер, энгэрийн камер, радио станц, дөрөвдүгээр багт цагдаагийн пост шинээр нээнэ.

"Тохилог хороолол" төсөл хэрэгжүүлнэ гэсэн. Энэ төсөл нь Жишиг хороолол төсөл, сая ярьсан хөтөлбөрөөс юугаараа ямар ялгаатай вэ?

"Тохилог хороолол" төсөл нь гэр хорооллын иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх зорилготой. Төслийн хүрээнд гэр хорооллын дундах авто замыг сайжруулахад анхаарч байна. 149.1 сая төгрөгөөр Дархан сумын нэгдүгээр багт 340 метр авто замыг хатуу хучилттай болгоно. Мөн 482.6 сая төгрөгөөр

Дархан сумын 3 дугаар багт 2.7 км сайжруулсан шороон замыг хатуу хучилттай болгох эхний үе шатны ажил буюу 900 метр авто замыг хатуу хучилттай болгохоор төлөвлөсөн. Дархан сумын 6,7,8 дугаар багийн дундах 3.2 км авто замыг хатуу хучилттай болгох ажлын эхний үе шатыг эхлүүлж, 1.0 км авто замыг 600.0 сая төгрөгөөр хатуу хучилттай болгоно. Дархан сумын 25 дугаар хорооллын доторх авто замыг хатуу хучилттай болгох эхний үе шатны ажил болох 500 метр авто замын ажлыг 200.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

"Гэр хорооллын дундах авто замын нөхцлийг сайжруулахаас гадна гэрэлтүүлгийн асуудлыг хамтад нь шийдэх боломж байгаа юу?"

Энэ жилийн хувьд Дархан сумын хоёрдугаар багт сайжруулсан шороон зам дагуу 480 метр газарт 12 ш лэд гэрэлтүүлэг, Эрдэнэ плазагаас Альфа хотхон хүртэлх 180 м газарт зургаан лэд гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлыг 17.9 сая төгрөгөөр, Мобикомын уулзвараас онгоцны буудал хүртэлх авто зам дагуух гэрэлтүүлгийн толгойг сүүлийн үеийн лед гэрэлтүүлгээр солих ажлыг 29.9 сая төгрөгөөр, Дархан сумын 15 дугаар багт дөрвөн хэсэг газарт 120 ш лед гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлыг 134.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийхээр төлөвлөсөн. Мөн Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар болон Монгол улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээс Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумын алслагдсан гэр хорооллын гудамжуудыг гэрэлтүүлэгтэй

болгох, аймаг, сум орон нутгийн өнгө үзэмж сайжруулах ажлын хүрээнд нэг сая еврогийн төслийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлсэн. Хэрвээ энэ гэрэлтүүлэг, 153 ш камер шинээр суурилуулах боломж бүрдэх юм.

"Орон нутгийн авто замыг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд ямар ажлууд хийгдэх вэ?

"Төв цэнгэлдэх хүрээлэнгээс Хараа голын төмөр бетон гүүр хүртэлх 1.4 км авто замын шинэчлэлтийн ажлыг 787.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байна. Замын ажлыг ирэх сард буюу тавдугаар сарын 30-ны өдөр ашиглалтад өгөх төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байгаа. "Шинэ-Хуучин Дархан"-ыг холбосон 8.0 км авто замын эхний хэсэг 2016 онд ашиглалтад орсон. Энэ замын дагуух ногоон байгууламж, явган зам, тохижилтын ажлуудыг энэ хавар хийнэ. Мөн орон нутгийн авто замыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд Дархан-Шарын гол чиглэлийн 47.9 км хатуу хучилттай авто зам, Дархан-Шарын гол чиглэлийн авто замын төмөр бетон гүүр, Хараа голын төмөр бетон гүүрийн засвар, Дархан сумын 11, 12, 13 дугаар хорооллын автозамыг, зурагтын толгой давуулж холбох 8 км авто зам, Хонгор сумаас Салхит баг хүртэлх 13.1 км авто зам, 15 дугаар багийн Мангирт хороолол доторх 2.1 км авто зам, Дархан сумын 1,2 дугаар багийн дагуух 6-н буудлаас уерийн далан хүртэлх 3.4 км авто зам, Дархан сумын 6, 7, 8 дугаар багийн авто зам, Дархан сумын 13 дугаар багийн авто зам нийт 54.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй есөн төсөл арга хэмжээг Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлэхээр зураг төсвийг хүргүүлээд байна.

...2017 онд аймгийн ЗДТГазар болон Дэлхийн Зөн олон улсын байгууллагатай хамтран 50, 50 хувийн хөрөнгө оруулалттайгаар буюу 804.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын V багт Хүүхэд хөгжлийн ордныг барьж, одоо ашиглалтад өгөхөд бэлэн болоод байна...

"Сургууль, цэцэрлэгүүдийг дэмжсэн хөрөнгө оруулалтын ажлууд багагүй жин дардаг. 2017 оны хувьд боловсролын салбарт зориулж хэчнээн төгрөг төсөвт суулгасан бэ?"

Дархан сумын V багт 25 дугаар цэцэрлэг шинээр ашиглалтад орж 100 хүүхэд хамрагдах боломжтой болсон. 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Шарын гол сумын II цэцэрлэгийн барилгын өргөтгөснөөр 35.0 хүүхэд хүлээж авах чадалтай хоёр анги нээж байна. Мөн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн хоёр ангийг 10.0 сая төгрөгийн үнэ бүхий стандарт ширээ санцраар хангахаар болсон. Мөн тус сургуулийн дотуур байрны засварын ажлыг Япон улсын өвсний үндэс төслөөр засварлана. "Од" цогцолбор сургуулийн

МЭДЭЭЛЭЛ

Дархан-Уул аймагт 2017 онд төсвийн хөрөнгө оруулалтаар 18.1 тэрбум төгрөгийн ажил хийгдэнэ



тус тус байгуулж ашиглалтад оруулна. Өндөр настны эрүүл мэндийг дэмжих, нөхөн сэргээх төв байгуулж, "Спорт цогцолбор"-ын барилгын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ. "Дархан Шарын" гол чиглэлийн

хөрөнгө оруулалтаар нийт 11.1 тэрбум төгрөгийн, орон нутагт улсын төсвөөс эрх шилжиж ирсэн 194.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн 1.4 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв болон замын сангийн 4.9 тэрбум төгрөг, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардаас 0.5 тэрбум төгрөг, нийт 18.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын 126 орчим төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Энэхүү бүтээн байгуулалтад эрхэм дарханчууд, барилгын салбарын нийт хамт олныг аймаг орныхоо хөгжлийн төлөө хамтран ажиллахыг уриалж байна" гэв.

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2017.04.24

[Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар] нь сонгогдсон эрх бүхий тендер оролцогчдоос [Баяндэлгэр сумын Соёлын төвийн барилгын засварын ажил]-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг [2017 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 15 цаг 00 минут]-аас өмнө [Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д нэвтрэн орж тендерийн материалаа /pdf файл/ цахим хэлбэрээр] ирүүлнэ.

Үнийн саналыг [2017 оны 05 сарын 02-ны өдрийн 16 цаг 00 минутаас]-аас өмнө [Сүхбаатар аймгийн Нутгийн удирдлагын ордон 3 давхарт (306 тоот өрөө, Мэргэжилтэн Баярмаа утас 99044893, 70518123)] хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан [2017 оны 05 сарын 02]-ны өдрийн [16 цаг 30 минут] -т нээнэ.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендер оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. (мэргэжилтэн С.Баярмаа, Утас:99044893, 70518123)

Дотоодны давуу эрх тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад тэдээллийг доорх хаягаар авч болно.

Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 3 давхар 306 тоот, Орон нутгийн өмчийн газар, мэргэжилтэн С.Баярмаа, утас 99044893

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2017/04/24

[Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар] нь сонгогдсон эрх бүхий тендер оролцогчдоос [Түвшинширээ сумын цэцэрлэгийн барилгын засварын ажил]-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг [2017 оны 5 дугаар сарын 2-ний өдрийн 14:00 цаг]-аас өмнө [Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д нэвтрэн орж тендерийн материалаа /pdf файл/ цахим хэлбэрээр] ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан [2017 оны 5 дугаар сарын 2-ний өдрийн 14:30 цаг]-т нээнэ.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендер оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. (Ахлах мэргэжилтэн Ч.Батболд, Утас:96510404, 70518123 Мэргэжилтэн Э.Уранчимэг 99037899)

Дотоодны давуу эрх тооцох эсэх. Үгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад тэдээллийг доорх хаягаар авч болно.

[Сүхбаатар аймаг Нутгийн удирдлагын ордон 3 давхарт 306 тоот өрөө Утас 99037899, 70510020]

ОЮУНЫ ТАГ



ОРУУЛАЛТ БҮРИЙН ЁСТОЙ

барилгын дээврийг 100.0 сая төгрөг, 18 дугаар сургуулийн барилгын дулааны үзэлийн ялтсан дулаан солилцуурт 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинэчилнэ. Мөн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байрны дулааны шугамыг 180.0 сая төгрөгөөр шинэчилнэ гээд маш олон ажлууд байна.

-Энэ жил "Ном", "Авьяас" хөтөлбөрийг хэрхэн дэмжих вэ?

"Ном", "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд 2013-2016 онд нийт 80.0 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байдаг. 2017 онд аймгийн ЗДПГазар болон Дэлхийн Зөн олон улсын байгууллагатай хамтран 50, 50 хувийн хөрөнгө оруулалттайгаар буюу 804.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын V багт Хүүхэд хөгжлийн ордныг барьж, одоо ашиглалтад өгөхөд бэлэн болоод байна. Хүүхэд хөгжлийн ордон бүрэн ашиглалтанд орсноор Дархан сумын хүүхэд багачууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжтой болох юм. Мөн "Ном", "Авьяас" хөтөлбөрөөс гадна "Спортлог Дарханчууд" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Бид олимпын эзэд төслийг хэрэгжүүлж 2016, 2017 онд хэрэгжүүлсэн. Мөн Авьяас хөтөлбөрийн хүрээнд 2013-2016 онд нийт 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр Дархан сумын Энэрэл цогцолбор сургуулиас 2017 онд Австри улсад зохиогдож буй Өвлийн параолимпийн анхны олимпын аварга төрлөө. Энэ бол дээрх хөтөлбөрүүдийн бодит үр дүн.

-Дархан-Уул аймаг өнгөрсөн жил "Шарилжгүй Дархан" хөтөлбөрийг өрнүүлж, нийтээрээ шарилжтай тэмцсэн. Энэ ажил үргэлжлэх үү?

Дархан-Уул аймагт амьсгалын замын харшлын чанартай нийт өвчлөлийн 62.5 хувь нь ургамлын гаралтай харшил эзэлдэг. Энэ жил Шарилжтай тэмцэх ажлыг тавдугаар сараас эхлүүлнэ. 6-8 дугаар саруудад шарилжийг хадах, тайрах, танах, хор цацна. Тус ажилд нийт 9.9 сая төгрөгийг зарцуулахаар тооцож байна. Мөн НААУГазрын үржүүлгийн талбайд өвлийн хүлэмж шинээр барих ажлыг 75.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.

-Өөр ямар төслүүдийг хэрэгжүүлэх вэ?

Дархан сумын VI, VII багт төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах ажлыг зохион байгуулна. Тодруулбал VI багт багийн төв, цагдаагийн хэсэг, өрхийн эмнэлэг ажиллах барилгыг 80.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр барина. VII багт төрийн үйлчилгээ явуулах байрыг 160.0 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөдөг байна. Мөн "Нэгдсэн эмнэлгийн харьяа Сэтгэц наркологиын төвийн барилгын дээвэр засварын ажлыг 54.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

МЭДЭЭЛЭЛ

Бүтээн байгуулагчидгаа талархал илэрхийлэв

2017 оны хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын нээлтийн үеэр 2016 оны хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд иэвдх зүтгэлтэй ажилласан Б.Ганбаатар захиралтай "Бурхант хясаат", Д.Хатанбаатар захиралтай "Ноён өндөр", Д.Ганбат захиралтай "Талст өргөө" компанид аймаг орон нутгаас талархал илэрхийлэв.

Замын засвар үйлчилгээнд ашиглах тоног төхөөрөмжүүдг хүлээлгээн өгөв

2017 оны хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын нээлтийн үеэр "Дархан Орон нутгийн зам тээвэр" ОНӨААТҮГ-т шаардлагатай байсан 43 сая төгрөгийн үнэ бүхий хоёр авто машин, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөв. Тус газар нь ИТХ-ын Тэргүүлэгчдийн 94 дүгээр тогтоолоор үзэгсэн байгуулагчид нэгдүгээр сараас эхлэн 17 албан хаагч, ажилчдын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа ажээ. Байгуулагдсан цагаас хойш өнөөдрийг хүртэл тус хамт олон зам тээврийн бодлогыг хэрэгжүүлэх үүднээс замын засвар арчлалтын ажлын бүртгэл судалгаа, нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудын судалгааны ажлыг хийж гүйцэтгэн найман аж ахуй нэгжтэй зорчигч тээвэрлэлтийн гэрээ байгуулан 196 иргэнийг баталгаат ажлын байртай болгожээ. Аймгийн хэмжээнд нийт 60 гаруй км хатуу хучилттай авто зам байдаг бөгөөд дээрх тоног төхөөрөмжөөр орон нутгийн замын засвар арчлалтын ажлыг технологийн дагуу сайн хийж гүйцэтгэнэ гэж тус газрын дарга Ц.Сэргэлэн яриллаа.

Баяр хүргэж байна

Г.Чинсанаа нь Дэлхийн Оюуны Өмчийн Академийн доктор /ph.d/ эрдмийн цол хүртсэн баяр хүргэж байна.

2017.4.14

ОХУ,ШВЕД,АНУ,ЧЕХ,ШВЕЙЦАРЬ,МОНГОЛ УЛС ДЭЛХИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН АКАДЕМИ

Table with financial data for 'Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын ТОГТООЛ'. Includes columns for year, category, and amount.

Table with financial data for 'АВТОТЭЭВРИЙН ҮНДСЭЙН ТӨВ' (Vehicle Fleet). Includes columns for vehicle type, year, and amount.

Table with financial data for 'АВТОТЭЭВРИЙН ҮНДСЭЙН ТӨВ' (Vehicle Fleet) with detailed descriptions of vehicle models and their specifications.

MEDIA STRESS

ДУУЛГАХ СОНИН

Дэлхийн тулааны урлагийн домог Эрнесто Хоост Монголд ирнэ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.СУМБЯА

Монголын холимог тулааны “Зэв” холбооноос ирэх тавдугаар сарын 6-нд “Аса” циркт болох “Zev Fight Night-1” тэмцээний талаар мэдээлэл хийлээ. Тус тэмцээнээс шалгарсан тамирчид 28-нд Японы Нагоя хотод болох “Stand Fighting Network K-Ing” олон улсын тэмцээнд оролцох эрхтэй болох ажээ. Хэвлэлийн хуралд “Зэв” холбооны капитан Асашёрюү Д.Дагвадорж, Зэв холбооны Удирдах зөвлөлийн гишүүн “Херо” энтертайментын найруулагч, захирал Б.Баатар, Зэв холбооны Гүйцэтгэх захирал Б.Баярбямба, Зэв холбооны менежер Ц.Ганзориг нар оролцоо. Монгол Улсын хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин, мэргэжлийн сүмогийн 68 дахь их аварга, Асашёрюү Д.Дагвадоржийн тухайд Монголын холимог тулааны “Зэв” холбооны капитаны үүрэг гүйцэтгэж, Монголын тулааны спортыг хөгжүүлэхээр болсон байна. Тэрбээр “Зэв” холбоонд капитан буюу ахмадаар ажиллаж, Монгол тамирчдад дэмжих байдал оролцоно. Асаршёрюү нэрийг ашиглаж “Team Asashoryu” нэрээр оролцвол илүү хүртээлтэй, олон хүний сонирхлыг татах болов уу. Энэ сарын 1-нд Японоос энэ тэмцээнд хоёр тамирчин оролцуулаар байна гэсэн санал ирсэн. Монголын залуучуудаа тулааны урлагаар дамжуулан дэлхийд гаргана гэдэгт итгэж байна. Цус үзсэн тулаан биш хүнлэг, ёс зүй, Монгол хүний эрхэмлэх чанарыг гол зорилго болгоно. Тамирчдад дэмжээд шилдгээ тодруулна. Монголчуудаа дээш нь гаргах, тив дэлхийд нэрийг нь цуурайтуулахыг хүсч байна” гэлээ.

64 кг жинд

Ирээдүй MMA клубын дасгалжуулагч Д.Батгэрэл-Нероес клубын Н.Бат-Эрдэнэ
Гаруда MMA клубын Б.Гантогтох -One team Г.Энхбаяр
67 кг жинд
Ирвэс клубын Н.Отгонбаатар - Мандал Файтинг клубын Г.Мөнх-Од
Бурхан халдун клубын А.Мөнхбаатар -Ихэр бээлий клубын Э.Батбаяр нар тулалдана.

Мөн энэ үеэр тус холбооны үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал Б.Баярбямбаас “ZEV Fight Night-1” тэмцээний талаар тодрууллаа.

“Зэв” холбооноос зохион байгуулж буй анхны “ZEV Fight Night-1” тэмцээн ирэх сарын 6-нд Аса циркэд болно гэлээ. Тэмцээний талаар тодруулахгүй юу?

Тавдугаар сарын 28-нд Японы кикбоксын олон улсын холбооноос Голландын алдарт тамирчин Эрнесто Хоосттой хамтран “Stand Fighting Network K-Ing” тэмцээн зохион байгуулна. Нийт таван жинд Японы таван тамирчин олон улсын таван тамирчинтай халз тулалдах юм. Олон улсын таван тамирчны хоёрыг нь Монголоос авах санал ирсэн. 64, 67 кг-ийн жингийн ангилалд Монголоос тамирчид тулалдах болсон. Манай холбооноос энэ хоёр тамирчныг энэ сайн тамирчин, тэр ялах боломжтой гээд шууд оноохыг хүсээгүй. Шагналын сан өндөртэй тэмцээн болохоор шударга байх үүднээс сонгон шалгаруулалт хийе гэж шийдсэн. Ийнхүү энэ сарын 6-нд болох “ZEV Fight Night-1” буюу манай холбооны анхны тэмцээн болж байна.

Тэмцээний дүрмийн тухайд?

“Stand Fighting Network K-Ing” тэмцээн кикбоксын дүрмээр явагдана. Нэг жинд дөрвөн тамирчин сонгож байгаа. Хоёр жинд найман тамирчин тулалдана. Гэхдээ сонгон шалгаруулалтыг сорилийн түвшинд биш мэргэжлийн тулааны стандартаар зохион байгуулна. Нэг жинд гурван тулаан болно гэсэн үг. Тамирчид тодорхой болсон. Бүгд бэлтгэлдээ гарсан байгаа.

Тамирчдыг хэрхэн сонгосон бэ?

Оролцож байсан уралдаан тэмцээн, гаргасан амжилтыг нь хараад тухайн жиндээ улсаа чансаа өндөр, шилдэг гэсэн тамирчдыг сонгосон. Монгол улсыг төлөөлж оролцоно гэдэг утгаараа “MGL-1” зэрэг мэргэжлийн тэмцээнд оролцож байсан болон түрүүлж байсан бүх тамирчны жагсаалтыг гаргаж байгаад жин тус бүрт дөрвөн тамирчин сонгосон.

Ивээн тэтгэж, дэмжин ажиллаж буй хувь хүн, албан байгууллага бий юу?

Олон хүн дэмжиж байна. Дархан Пүүжээ гээд алдартай уран дархан хүн бий. Тэр хүн сумны зэвийг хүрлээр цутгаад, оюу эрдэнийн чулуу шигтгэсэн суурьтай сайхан цом хийж өгч байгаа. Энэ цом бол тэр чигтээ урлагийн бүтээл. Тайланд дахь Монголын ЭСЯ-аас гэхэд тулааны бээлий, хувцас хэрэглэлээр туслаж байх жишээтэй. “Exclusive” брэнд Ринг охидын болон тамирчдын хувцас,

нөмрөгийг дэмжиж урлаж байгаа. “Хасбуу” студийн хамт олон тамирчдын зураг авч дэмжиж байна. Тэмцээний найруулга, энтертаймент талыг “Херо” энтертайментийн найруулагч Б.Баатар хийнэ. Мөн эрдэс баялгийн эдийн засагч Л.Наранбаатар дэмжиж байгаа. Эдгээр хүн бол тулааны спортод сонирхолтой, томоохон контентуудыг анхлан бий болгосон туршлагатай. Олон хүний сэтгэл шингэсэн сайхан тэмцээн болно. Гадаадын том тэмцээнүүд ямар болдог, яг л түүн шиг болно. Зохион байгуулагчдын хувьд урьд өмнө тэмцээн хийж байсан туршлага бий. Дээр нь найруулга дээр мэргэжлийнхэн орж байна. Мөн Японоос мэргэжлийн шүүгчид ирж, ажиллана.

Эрнесто Хоост Монголд ирнэ гэсэн үү?

Тийм ээ. Энэ тэмцээний бас нэг онцлог нь дэлхийн тулааны урлагийн домог, нэрт тамирчин, K-1-ий хүнд жингийн дэлхийн дөрвөн удаагийн аварга Эрнесто Хоост Монголд ирж, тэмцээнийг үзэх юм. Хоост тавдугаар сарын 4-нд Монголд ирнэ гэдгээ албан ёсоор мэдэгдсэн. Жин үзэх, шагнал гардуулах арга хэмжээнд оролцоно. Нэгэнт энэ домогт тамирчныг урьж авчирсных бас тамирчиддаа хичээл заалгана. Хоост нэг өдөр тамирчдад семинар хийж, туршлага хуваалцан, арга техник заана. Мөн тавдугаар сарын 28-нд болох “Stand Fighting Network K-Ing” тэмцээний дүрэм, зохион байгуулалтыг танилцуулах юм.

Аливаа тэмцээн уралдааныг зохион байгуулахад санхүүгийн хувьд бэрхшээл гарах тохиолдол бий. Танай холбоо энэ асуудлаа хэрхэн шийдвэрлэж байна вэ?

Аливаа мэргэжлийн байгууллага гэдэг өөрөө өөрийгөө санхүүжүүлээд явах механизмтай байж хөгждөг. Тиймээс бид тэмцээн уралдаанаа тогтмолжуулаад явна. Тэгэхээр үзэгчдийн тоо нэмэгдэнэ. Мөн тамирчдаа олонд таниулж, алдаршуулах талаар ажиллана гэсэн зорилттой. Бизнес загвараа гаргасан. “UFC”, “One Championship”, “Road” “FIGHT NIGHTS” холбоод яаж ажилладагийг сайн судласан, Монголынхоо нөхцөлд тааруулна. Ер нь бол контент болгоно гэсэн төлөвлөгөөтэй. Контент болгож, зар сурталчилгаа, ивээн тэтгэгчидтэйгээ хамтран ажиллана. АСА цирк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Yokohama брэнд дэмжин ажиллахаар болсон. “Golds gym”-ээс энэ тэмцээнд шалгарсан хоёр тамирчинд бүтэн жил бэлтгэл хийх эрх гардуулж, хамтран ажиллана гэх мэт ивээн тэтгэгч байгууллагууд олон байгаа.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 13
Шөнө -4

Нөгөөдөр
Өдөр 17
Шөнө -1

Өдрийн зурхай

2017-04-25 / Билгийн тооллын 29

Үс засуулбал: Сүлд тэнэж
одно
Наран ургах, шингэх:
05.48-19.57



Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг туу нөлөөтэй тул элдэв үйлд хяналттай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус туулах, лусыг тахиx, тангараг тавиx, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэлцэл хийх, сэтгэлд сэтгэй газар очиход луй. Өдрийн сайн цаг нь хулаана, үхэр, туулай, торь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлэх буюу засуулахад тохиромжгүй.

Бидэнд тохиолдсон

КҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Solosafe Soko

Нэг удаа барилгын материалын дэлгүүр орох гээд явж байсан чинь хэдэн залуус портертой араас шүгэлдээд, сигналдаад боддоггүй. Би нь үсээ ороогоод задгай тавьж, өндөр өсгийт өмсөөд л лаг дээрээ тавьчихсан явж байв оо. Гайхаад харсан чинь нэг л танил портер. Тэгсэн харин нөхөр ажлынхантайгаа явж байдаг байгаа. Би өөрийг нь таниад очсон чинь ээрч сандраад сүйд болсон. Намайгаа танихгүй аальгүйгээд орой нь алуулдаг юм байгаа биз дээ. Ха ха ха

THE FATE OF THE FURIOUS
APRIL 14
IN THEATERS AND MAX

GHOST IN THE SHELL

Нэгэн эмэгтэй Дом-г хүчээр гэмт хэрэгт татан оролцуулж хамгийн дотно хүмүүсийнх нь эсрэг ажиллуулна. Гэр бүл шиг болсон тэд урьд өмнө учирч байгаагүй сорилттой тулгарна.

ТЭНГИС
ХЭНГЭДЛИЙН КАРТ

ТАСАГВАРЫН ҮНЭ
- Мугаар, Пунаа, Нуура гэрэгт
2000 Tөг
- Бусад ирүүлж
3000 Tөг

Аймшигтай ослоос амь гарсан бүсгүйг төгс чадвартай кийборг болгон өөрчилж компьютерийн хакеруудын бүлэглэлийн эсрэг илгээнэ.

Уулда, Поппоки, Уулзүй